



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ I-Р УЛИРАЛЫН БАЙДЛААР АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААРХ ТАЙЛАН**

АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ



1. Мэдээллийн технологийн төвөөс “Тэтгэврийн зөрүү хуваарь үүсгэх, Тэтгэврийн олголт хаах , Үйлдвэрлэлийн ослын сангаас хариуцах ноогдуулалт үүсгэх талаар цахим сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр 5 албан хаагч хамрагдлаа.



2. Мэдээллийн технологийн төвөөс “Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт”-ын талаар цахим сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр 7 албан хаагч хамрагдлаа.



3. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1.15-д заасан архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах чиг үүргийн хүрээнд Архивын ерөнхий газраас 2025 онд зохион байгуулах “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт”, “Төрийн архивын ажлын зохион байгуулалт” сургалтад 1 албан хаагч 2025 оны 01 дүгээр сарын 29-30-ний өдрүүдэд цахимаар сургалтад хамрагдсан.



4. Монгол хэлний тухай хуулийн 7.2-т “Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж заасны дагуу тус газрын алба хаагчид монгол бичгийн анхан шатны сургалтыг СХД-ийн Насан туршийн боловсролын төв-ийн багш Н.Туяа багштай хамтран зохион байгууллаа. 2025 оны 02 дүгээр сарын 04-ны өдөр 20 албан хаагч сургалтад хамрагдсан.



5. “ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ , БЭЛЭН БАЙДЛАА ХАНГАХ” сэдэвт сургалт. СХД-ийн Онцгой байдлын хэлтсийн, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, ахмад Ө.Ууганжаргалтай хамтран зохион байгууллаа. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 30 албан хаагч сургалтад хамрагдсан.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ I-Р УЛИРАЛЫН БАЙДЛААР ТӨСӨВТ БАЙГУУЛАГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААРХ ТАЙЛАН

1. “ЭМНЭЛГИЙН ХУУДАС ОЛГОХ, ХЯНАХ ЖУРАМ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ” сэдэвт сургалт

СХД-Нийгмийн даатгалын газрын дарга Б.Жаргалсайхан, Магадлагч эмч Г.Ариунжаргал нар СХД-Эрүүл мэндийн төв, СХД-Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Амбулаторийн 106 ажилтанд, Эмнэлгийн хуудас олгох, хянах журам, тушаал шийдвэр тогтоолын хэрэгжилтийн талаар цахим, тэнхим хосолсон сургалтыг 2025 оны 01 сарын 29 өдөр цахимаар, 02 дугаар сарын 07, 11-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулан ажиллалаа.



2. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛЬ”, “ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР”-ийн талаар сургалт

Сонгинохайрхан дүүргийн ОБЕГ-ын дэргэдэх 179 дүгээр ангийн 18 албан хаагчдад 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Түмэнжаргал сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Д.Нарантуяа нар мэдээлэл, сургалт өгч албан хаагчдын сонирхсон асуултад хариулан ажиллалаа.



3. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛЬ”, “ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР”-ийн талаар сургалт

Сонгинохайрхан дүүргийн Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн 28 албан хаагчдад 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр, Захиргаа хяналтын хэлтсийн дарга Л.Түвшин, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Д.Нарантуяа нар мэдээлэл, сургалт өгч албан хаагчдын сонирхсон асуултад хариулан, хамтран ажиллалаа.



4. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛЬ” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ 16 албан хаагчдад 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Түмэнжаргал, Орлого шимтгэлийн өр хариуцсан байцаагч, мэргэжилтэн О.Нямсүрэн нар мэдээлэл, сургалт өгч албан хаагчдын сонирхсон асуултад хариулан, хамтран ажиллалаа.

